



## 3 Нифай 17–19

(9-Р САРЫН 28-ААС 10-Р САРЫН 11)

**Е**сүс Христ нифайчуудад тохинуулснаар Өөрт нь ирсэн хүн бүрд Өөрийн агуу хайр хийгээд эдгээгч хүчийг харуулсан. Аврагчтай уулзсан нифайчуудын туршлагаас бид юу сурч болох вэ?



### ЯРИЛЦЛАГА

- Хэрэв та нифайчуудын дунд байсан бол Аврагчаас юугаа эдгээлгэхийг хүсэх байсан бэ? Та Түүнд юу гэж хэлэх вэ?
- Та нифайчуудын адил Христэд ирж, Түүний хайр, эдгээгч хүчийг өөрийн амьдралд мэдэрэхийн тулд юу хийж болох вэ?
- Хэзээ та Аврагчийн хайрыг мэдэрч байсан бэ? Та тэр хайрыг хэрхэн мэдэрсэн бэ?

# Бид Христийн эдгээгч хүчийг хэрхэн мэдэрч болох вэ?

### Нифайчуудад тулгарсан сорилт бэрхшээл

Есүсийг ирэхийн өмнөх хэдэн арван жил үймээн самуунтай байв.

Нифайчууд дараах бэрхшээлтэй тулгарсан. Үүнд:

- |   |   |  |  |   |   |
|---|---|--|--|---|---|
| • Шашны мөрдлөг хавчлага (3 Нифай 1:9-ийг үзнэ үү). | • Ёс бус хийгээд жигшүүрт үйл (3 Нифай 2:3; 7:7-г үзнэ үү). | • Дайн дажин (3 Нифай 2:17-г үзнэ үү). | • Анги давхаргын ялгаварлал (3 Нифай 6:10–14-ийг үзнэ үү). | • Иргэний үймээн (3 Нифай 7:1–4-ийг үзнэ үү). | • Гурван өдөр харанхуйлахад тохиолдож өнгөрсөн байгалийн гамшгууд (3 Нифай 8-ыг үзнэ үү). |
|---|---|--|--|---|---|



### Нифайчуудын дундах Христийн тохинуулал

Аврагч нифайчууд дээр айлчлан ирэхдээ “ямар нэгэн байдалд зөвхөн зүдэрсэн” (3 Нифай 17:7) хүн бүрийг ирж, эдгэр хэмээн хэлсэн. Түүний урилга зөвхөн дөнгөж тохиолдсон сорилтуудад хамаатай байсангүй. Энэ нь нифайчуудын амьдралынхаа туршид олсон нүдэнд харагдах мөн нүднээс далд байх шарханд ч бас хамаатай байв. Есүс Христ тэднийг “нэг бүрчлэн” эдгээсэн (3 Нифай 17:9) бөгөөд “нэг нэгээр нь” тохинуулсан (3 Нифай 17:21).